



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих
өдрийг зохион байгуулах тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 9.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх, зорилгоор
ТУШААХ НЬ:

- Жил бүрийн "3 дугаар сарын 18"- ны өдрийг "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдөр" болгон зохион байгуулсугай.
- Энэ оны Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдрөөр "Эрчүүдээ хайлралаа" уриан дор зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдрийг орон нутаг, байгууллагын онцлогтойгоо уялдуулан зохион байгуулж, тайланг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлэхийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн дарга, захирал нарт даалгасугай.
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет ажиллуулах бэлтгэл ажлыг хангахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхбат/-т, "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих үндэсний стратеги"-ийг 2013 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Ц.Цолмонгэрэл)-т даалгасугай.
- Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сан, орон нутгийн төсөвт тогтмол тусгахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Д.Дамдиндорж/-т, Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Хатанбаатар/-д даалгасугай



001793

Эрүүл мэндийн сайдын 2013 оны дугаар
сарын 03-ны 11 өдрийн 74 дугаар
тушаалын хавсралт



245
**Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдрийг
зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө**

	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах газар
1	Хэвлэлийн бага хурал зохион байгуулах	2013.03.15	НЭМХ
2	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдрийн нээлт хийх	2013.03.18	НЭМХ, ЭТХ
3	Эрэгтэйчүүдэд зориулсан сурталчилгааны тараах материал гаргах	2013.03.18	НЭМХ
4	Эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	2013.03.18	ЭТХ
5	“Эрчүүдээ хайрлая” сэдвээр лекц зохион байгуулах	2013.03.18	ТЗУГ
6	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар телевизийн ток шоу зохион байгуулах	2013.03.17	ТЗУГ (Хэвлэл мэдээллийн алба)